

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРАЛД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс нь Цагдаагийн албаны тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, улсын хэмжээнд зохион байгуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжил, арга зүй, удирдлагаар ханган, үр дүнг тооцож ажиллалаа.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Цагдаагийн байгууллагаас Хууль зүй, дотоод хэргийн яамны Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран байгаль орчны тэнцвэрт байдал, уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийг зохистой ашиглах, учирсан хохирлыг нөхөн сэргээх, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх, байгаль хамгаалах ажилд иргэн бүр идэвх санаачлагатай оролцох соёлыг төлөвшүүлэх байгаль орчинтой зөв харьцаж, хамгаалах мэдлэг ойлголтыг иргэд, олон нийтэд хүргэх зорилготой “Байгалиа хамгаалъя” тусгай арга хэмжээг 2 дугаар улиралд улсын хэмжээнд зохион байгуулах саналтайгаар,

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийн хүрээнд байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, албаны нэр хүндийг дээшлүүлэх, иргэд олон нийтэд эерэгээр сурталчлах чиглэлээр видео болон зурагт контент бүтээж хүргэх ажлыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагатай хамтран эхлүүлэх саналтай танилцуулгыг Цагдаагийн байгууллагын удирдлагад тус тус танилцуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний нэдсэн төлөвлөгөөний дагуу залилах, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шалтгаан нөхцөлийг арилгах, иргэд, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, ухамсар хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажил, арга хэмжээг 3 дугаар сарын 15-ны өдрөөс 31-ний өдрийн хооронд зохион байгуулах төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад хүргүүлсэн.

Иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ногоон бүс” төслийн жишигт нийцүүлэн телехяналтын нэгдсэн системийг сайжруулах, хяналтад авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж хэрэгжүүлэх талаар Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт энэ оны 02 дугаар сарын 16-ны өдөр 01/126 дугаартай “Үүрэг, ажлын чиглэл”-ийг боловсруулан хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газартай 2022 онд хамтран тус дүүргийн 1,2,3 дугаар хороонд “Ногоон бүс” төслийг хэрэгжүүлсэн сайн туршлагыг цаашид хамтран хэрэгжүүлэх Нийслэлийн 6 дүүргийн Засаг дарга нарт энэ оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/127, 21 аймгийн Засаг дарга нарт энэ оны 02 дугаар сарын 16-ны өдөр 01/128 “Хамтран ажиллах” тухай хүсэлтийг хүргүүлж, Хан-уул, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар, цагдаагийн газар, хэлтсүүдэд мэдээлэл, танилцуулга хийж, дэмжлэг, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажилласан.

Энэ оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”, 30-ны өдөр “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх дэд зөвлөл”-ийн хуралд Цагдаагийн байгууллагаас 2022 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнаж, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн.

Мөн Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс батлагдаж ирсэн “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийн хүрээнд алба хаагчдыг гэмт хэрэг, сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг энэ оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 14-ний өдрийн хооронд зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд видео контент 37, зурагт хуудас 7, нийт 44 мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулан түгээж иргэд олон нийтэд хүргэсэн.



Нийслэл хотод үүссэн хүн амын төвлөрлөөс шалтгаалан гэмт хэрэг, зөрчлийн дийлэнх хувь нь үйлдэгдэж байгаатай холбогдуулан цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Монгол Улсын Засгийн газраас баримталж буй хот, хөдөөгийн тэнцвэртэй байдлыг хангах чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн ажил, арга хэмжээг зохион байгуулах саналыг авч нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/28 дугаар тушаалаар байгуулагдан Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 97 анги, байгууллагаас санал авч, холбогдох судалгааг хийж боловсруулан, танилцуулгыг бэлтгэн Цагдаагийн ерөнхий газрын дарга, зөвлөлийн гишүүдэд танилцуулсан.

Хоёр. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд нэгдсэн 2, хэсэгчилсэн 134, нийт 136 ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна.Тухайлбал:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сар шинэ-2023” тусгай арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:


Арга хэмжээний хүрээнд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гудамж талбай, олон нийтийн газарт хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр давхардсан тоогоор авто эргүүлийн 1570 чиглэлд 4046 алба хаагч, явган эргүүлийн 5452 чиглэлд 10809 алба хаагч нийт 14855 алба хаагч үүрэг гүйцэтгэж 7784 объект, 49113 хүн, 31458 тээврийн хэрэгсэл шалгаж, гэмт хэрэг, зөрчлийн 15986 дуудлага, мэдээллийг хүлээн авч шалган, 4186 зөрчлийг илрүүлэн, 4455 иргэнд 12.1 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 28 зөрчлийг илрүүлэн, 37 тээврийн хэрэгслийн түр саатуулж, 1827 хүнийг эрүүлжүүлж, 995 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгсөн байна.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/832 дугаар захирамжийг зөрчихгүй байх талаар согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг нийт 2269 аж ахуй нэгж, байгууллагад мэдэгдэл, шаардлага хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажилласан.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 удаагийн уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж давхардсан тоогоор 83800 иргэнд яриа таниулга хийж, 5 төрлийн сэрэмжлүүлэг бүхий 25000 ширхэг зурагт хуудас, гарын авлагыг бэлтгэн 81 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбарт байршуулан, иргэд олон нийтэд хүргэсэн.

“Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс” болон албад, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын пэйж хуудсаар тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, мэдээлэл сурталчилгааны чиглэлээр “Иргэн та сонор сэрэмжтэй байж халаасны хулгайчид боломж бүү олго”, “Таны эд зүйл яг одоо таны халаасанд байна уу”, “Таны хөрөнгийг та хамгаална”, “Орон байраа удаан хугацаар орхиж явахгүй байх”, “Сар шинийн мэндчилгээ”, “Хүүхдийн эрхийг хүндэтгэх”, “Сэрэмжлүүлэг”, “Бүхий л хэрүүл маргаан дуу хоолойны өнгөнөөс эхэлдэг”, “Хүүхэд бүр аюулгүй орчинд амьдрах эрхтэй”, “Таны хүүхэд яг одоо хаана хэнтэй юу хийж байна вэ?” зэрэг видео мэдээлэл 18, зурагт хуудас 26, нийт 44 мэдээлэл байршуулсныг давхардсан тоогоор 1,675,966 хүнд хүрч, 54903 хүнд таалагдаж, 190,785 удаа бусадтай хуваалцаж, 6529 хүн эерэг сэтгэгдэл үлдээсэн үзүүлэлттэй байна.

Цагдаагийн байгууллагаас 2023 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан Залилах, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 31-ний өдрийн хооронд улсын хэмжээнд зохион байгуулж салбарын эрдэмтэн, мэргэшсэн судлаач, ГССҮТөв, Шүүх шинжилгээний эмч, Нийслэлийн прокурор, Өмгөөлөгчдийн холбоод, хувь уран бүтээлчид дэмжин оролцож, иргэд, олон нийтэд дээрх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, ухамсар хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн эрх зүйн зөвлөгөөг цуврал байдлаар хүргэж хамтран ажилласан.



Ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сурагчид болон их дээд сургуулийн оюутан залуучуудыг Залилах, Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэдэнд хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор сургалт 92, зөвлөгөөн 13, хэлэлцүүлэг 4, өдөрлөг 4, уралдаан тэмцээн 5 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, нийт 6164 хүн хамрагдаж, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр 545 мөрдөгчийн мэдэгдэл бичиж, 332 мэдэгдлийн хариу авч ажилласан.

Арга хэмжээний хүрээнд дээрх 2 төрлийн гэмт хэргийн онцлог, үйлдлийн арга, хүлээлгэх хариуцлага зэргийг тусгасан 40 төрлийн зурагт хуудас бэлтгэн

түгээж, урлаг, спортын олны танил 35 хүнээр уриалга гаргуулж, нийт 112 мэдээ, мэдээлэл бэлтгэн хүргэсэн.

Мөн үүрэн холбооны оператор компанийн хэрэглэгч нарт “Залилагч олон маск зүүж, бидний дунд оршиж, үргэлж хохирогч хайж байдаг”, “Таны уурласан үедээ гаргасан үйлдлээс болж хэн нэгэн хохирох ёсгүй” гэсэн агуулга бүхий масс мессежийг илгээж, фм радиотой хамтран тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургамжит үг, нөлөөллийн титэм үг боловсруулж, цаг тутам мэдээлсэн.

Арга хэмжээний хүрээнд бэлтгэгдсэн мэдээ, мэдээллийг гудамж талбай, олон нийтийн газарт байрлах 20 лед, 9 хулдаасан самбарт байршуулж, ухуулга нөлөөллийн 42 төрлийн 1732 ширхэг гарын авлага, 385 төрлийн 2810 ширхэг санамж сэрэмжлүүлгийг бэлтгэн тарааж гэмт хэрэг, зөрчлийг бууруулах таслан зогсоох чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг таниулах зорилгоор хэвлэл мэдээллийн 55 байгууллагатай хамтран 35 мэдээ сурвалжлаг, 28 ярилцлага өгч ажилласан.

Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2212 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 416 нэгжээр буюу 15.8, залилах гэмт хэрэг 3543 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеэс 225 нэгжээр буюу 6.0 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо Сүхбаатарын талбайд 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 29 өдөр зохион байгуулагдсан жагсаал, цуглааны оролцогчдын тоог нэмэгдүүлэхгүй байх, эрүү, хэв журмын нөхцөл байдал хүндэрч, нийтийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, үүссэн нөхцөл байдалд уялдуулан цахим орчинд явагдаж байгаа мэдээ, мэдээллийн урсгалыг боломжит байдлаар эерэгжүүлэх, нийгмийн сэтгэл зүйд тодорхой түвшинд нөлөө үзүүлэх зорилгоор “Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс” пэйж хуудсаар видео мэдээлэл 11, постер 16, нийтлэл 6 зэрэг нийт 53 мэдээ мэдээллийг цахим орчинд түгээсэн нь 41,598 хүнд таалагдаж, 1,032,049 хүнд таалагдаж, 3689 хүн сэтгэгдэл үлдээж, 5,769.308 хүнд хүрсэн байна.

Угаарын хий буюу нүүрс хүчлийн дутуу ислийн хордлогын шалтгаан нөхцөл, хор аюулын талаар иргэд, олон нийтэд ойлголт, мэдээлэл өгөх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд “Угаарын хий” тусгай арга хэмжээг зохион байгуулж иргэд, олон нийтэд угаарын хийн хордлогын талаарх ойлголт, мэдээлэл өгөх, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, зөв галлагаа, угаар мэдрэгчийг хэрхэн зөв ажиллуулах талаарх заавар, зөвлөгөө, зөвлөмж бүхий зурагт хуудас 24, видео мэдээ 7, нэвтрүүлэг 3, нийтлэл 3, нийт 37 мэдээ, мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээж иргэд олон нийтэд хүргэсэн.

Цахим орчинд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 оны 01 дүгээр сарын 23-наас 27-ний өдрийн хооронд мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулан “Педофилл ба хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ”, “Цахим залилан”, “Хуурамч хаяг”, “Зөрчилтэй контент”, “Гэмт хэргийн статистик мэдээ, мэдээлэл”, “Олон нийттэй харилцах нэгж, түүний гүйцэтгэх үүрэг” сэдэвт видео мэдээ 6, “Цахим гэмт хэргийн өсөлт, бууралт”, “Цаг тутамд цахим гэмт хэрэг үйлдэгдэж байна”, “Хууль бус цахим хаягийн хязгаарлалт”, “Pedophile буюу хүүхдээс бэлгийн таашаал авагчид”, “Цахим тролл”, “Хандах газартай боллоо” сэдэвт зурагт постер 6, нийт 12 мэдээ, мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээж ажилласан.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТЭС**